



“МОНГОЛЫН ЗАЛУУ ЭРДЭМТДИЙН ХОЛБОО” ТББ

ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН ЗАХИРГААНД

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
1-р хороо, ЭТӨ-5, СЭЗИС, Утас: +(976)-99099435;
Цахим шуудан: info@mysa.mn, mysa@gmail.com

_____ 2022.10.06 _____ № _____ 22/13 _____
танай _____ № _____ -т

Эрдэм шинжилгээний бага хурал
зохион байгуулах тухай

Монголын залуу эрдэмтдийн холбоо нь 2004 оноос өнөөг хүртэл дотоод, гадаадад эрдэм шинжилгээний ажил эрхэлж буй Монгол улсын иргэн залуу судлаач, эрдэмтэд бүх талын дэмжлэг үзүүлэх, гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах, гадаад орнуудын залуу эрдэмтэд, холбоодтой хамтран ажиллах, Монгол улсын шинжлэх ухаан, технологийн хөгжилд мэдлэгийн хөрөнгө оруулалт хийх зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд жил бүр Хүрэлтогоот эрдэм шинжилгээний бага хурлыг уламжлал болгон зохион байгуулдаг билээ.


Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2010 оны 07-р сарын 01-ний 324-р тушаалаар батлагдсан Сайдын нэрэмжит грант олгох журам-ын дагуу залуу эрдэмтэд, судлаач нарын дунд уг хурлыг шинжлэх ухааны 7 салбар болгон МЗЭХ, БШУЯ, ШУА, ШУТС болон их дээд сургуулиудтай хамтран ХҮРЭЛТОГООТ-2022 хурлыг 11-р сарын 12-ны өдөр зохион байгуулахаар ажиллаж байна.

Уг ЭШБХ-д ирүүлсэн бүтээлүүдэд эхний шатны мэргэжлийн хянан магадлагаа хийгдэж шаардлага хангасан бүтээлүүд ХҮРЭЛТОГООТ-2022 хуралд илтгэл тавьж хэлэлцүүлэгдэх ба зохиогчийн албан ёсны эрхтэйгээр хэвлэгдэн нийтлэгдэх болно. Мөн түүнчлэн уг хуралд шалгарч илтгэлээ хэлэлцүүлсэн залуу судлаачид тухайн салбар хуралдаанд шилдэгээр шалгарч, нийт 14 залуу судлаач нар БШУЯ-ны сайдын нэрэмжит дөрвөн сая төгрөгийн грантын эзэн болох юм.

Иймээс та бүхэн ХҮРЭЛТОГООТ-2022 ЭШБХ-д өөрийн байгууллага, сургуулийн залуу судлаач, нарыг идэвхитэй оролцуулахыг хүсье.

ХҮНДЭТГЭСЭН,

МОНГОЛЫН ЗАЛУУ ЭРДЭМТДИЙН
ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ХАНДМАА

ХҮРЭЛТОГООТ-2022 ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ

Хурлын үндсэн чиглэлүүд:

1. Анагаах ухааны салбар хуралдаан
2. Байгалийн ухааны салбар хуралдаан
3. Газарзүй, геологийн салбар хуралдаан
4. Нийгмийн шинжлэх ухааны салбар хуралдаан
5. Техник, технологий, инновацийн салбар хуралдаан
6. Хөдөө аж ахуй, биотехнологийн салбар хуралдаан
7. Эдийн засаг, бизнесийн салбар хуралдаан

Шагналын сан:

Тэргүүн байр – 14 судлаач, тус бүр БШУЯ-ны сайдын грант 4 сая төгрөг
Дэд байр – 7-14 судлаач, тус бүр өргөмжлөл

Хурлын бүртгэлийн хураамж:

МЗЭХ-Гишүүд : төлбөргүй
Дотоодын судлаач : 50,000 төгрөг
Гадны судлаач : 50 доллар

Холбоо барих:

Салбар	Утас	Цахим хаяг
Байгалийн ухааны салбарын залуу эрдэмтдийн холбоо	Д.Лхагвасүрэн 98000599	khureltogoot.nature@gmail.com
Анагаахын Залуу Судлаачдын Монголын Холбоо	О.Зэсэмдорж 99225977	khureltogoot.med@gmail.com
Газарзүй, геологи	Д.Батсүрэн 99040913 П.Цэенханд 80991878	khureltogoot.geo@gmail.com
Нийгмийн шинжлэх ухааны залуу эрдэмтдийн холбоо	П.Цэрэнбазар 99996586	khureltogoot.soc.eco@gmail.com
Хөдөө аж ахуй-Биотехнологийн залуу судлаачдын холбоо	Б.Баяр-энх 88997925, 99797723	khureltogoot.biology@gmail.com
Монголын Эдийн засаг, бизнесийн залуу эрдэмтдийн холбоо	З.Отгон 91910601	khureltogoot.eco.inno@gmail.com
Технологи, инновацийн зауу судлаачдын нийгэмлэг	Т.Батгэрэл 99253418	khureltogoot.tech.inno@gmail.com